

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ПРОТОКОЛ

2023 оны 4-р сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот, ТВИН ТАУЕР

“Дархан гурил тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4-р сарын 30-ны өдрийн 12.10 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, ТВИН ТАУЕР-2 байр 307 тоотод эхлэв.

Хурлын даргаар томилогдсон Ш.Энхтөр хурлыг удирдан явуулав.

Хурлын дарга Ш.Энхтөр тооллогын комиссын бүрэлдхүүн Д.Мөнхцэцэг, Н.Ариунтунгалаг нарыг танилцуулж, тооллогын комиссын гишүүн М.Өлзийсүрэн нь өвчний улмаас ирэх боломжгүй болсонг танилцуулаад тооллогын комиссын дарга Д.Мөнхцэцэгийг хурлын ирцийн талаар мэдээлэл хийхийг хүслээ.

Д.Мөнхцэцэг: Хуралд нийт 614603 хувьцаа эзэмшигчдээс 553891 ширхэг хувьцааг эзэмшигчид буюу нийт хувьцааны 90,12%-ийг эзэмшигчид ирсэн байна гэв.

Хурлын дарга Ш.Энхтөр: Компанийн тухай хууль болон “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5.5.21-д зааснаар ирц хүчин төгөлдөр тул хурлыг хуралдуулахаар шийдвэрлэв.

Хурлын дарга Ш.Энхтөр: Ээлжит хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
3. Зохион байгуулалтын асуудал

Оролцогчдын 100% саналаар хэлэлцэх асуудлыг батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хурлын дэгийг уншиж танилцуулав. /дэг хавсаргасан/

Хурлын дэгийг 100% санал нэгтэй батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал “Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт”-ийг хэлэлцэж батлах асуудал байгаа. Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мөн “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2022 оны

үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг тус тус уншиж танилцуулав. Тайлан, дүгнэлтийг хавсаргалаа.

Хурлын дарга Ш.Энхтөр: Тайлан, дүгнэлттэй холбоотой асуух асуулт, санал байна уу? Санал, асуулт гарсангүй.

Хурлын дарга Ш.Энхтөр: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт-ийг батлах бол гараа өргөнө үү, мөн саналын хуудсанд холбогдох тэмдэглэл үйлдэн баталгаажуулахыг хүсч байна.

Хуралд оролцогчдын 100% саналаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцэхээр ТУЗ-ийн хурлаас шийдсэн. Гэтэл манай компанид хөрөнгө оруулах сонирхолтой иргэд, хуулийн этгээдүүдийн ажил давхацсан, зах зээлийн судалгааны дүн хараахан гараагүй, хамтрагчдын оролцох олон улсын хурлын төв өөрчлөгдсөнөөс төлөвлөсний дагуу хүрэлцэн ирж амжаагүй тул энэ хурлаар хэлэлцэхээр товлосон 2, 3 дахь асуудлуудыг хэлэлцэх боломжгүй болсон. Үйлдвэрлэлийг сэргээх, экспортод бүтээгдхүүнээ гаргахтай холбогдуулан гадны хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах ажлын явц, үр дүнгээс шалтгаалан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж холбогдох шийдвэрүүдийг гаргах нөхцөл үүсч байна.

Тооллогын комиссын дарга Д.Мөнхцэцэг саналын хуудсуудыг нэгтгээд тогтоолоо танилцууллаа.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хэлэлцсэн асуудлыг дүгнэж хурлын тогтоолын төслүүдийг танилцууллаа. Хуралд оролцогсод 100%-ийн саналаар батлав.

Ш.Энхтөр: Дархан гурил тэжээл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж төлөвлөсөн асуудлуудаа хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Хурлын материалаа Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж ХК-д бүртгүүлэх ажлыг ТУЗ, гүйцэтгэх удирдлагад даалгаж байна. Хуралд оролцсон та бүхэнд талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хурлыг хааж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд идэвхтэй оролцохыг хүслээ.

Хурал: 2022 оны 4-р сарын 30-ны 13.00 цагт өндөрлөв.

Хурлын дарга

Хурлын тэмдэглэл хөтөлсөн



Ш.Энхтөр

С.Буянхишиг